

**БНСУ-д зохион байгуулагдсан Дэлхийн цаг уурын байгууллагын бүсийн сургалт  
“Синоптик инженерүүдийн ур чадварыг дээшлүүлэх” сэдэвт богино хугацааны  
сургалтанд хамрагдсан тайлан:**

Улаанбаатар

2025.07.31

Нислэгийн цаг уурын төвийн, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн, урьдчилсан мэдээлэхийн ерөнхий технологич инженер Ц.Баярмаа миний бие 2025 оны 5 дугаар сарын 12-23-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын нийслэл Сөүл хотноо Дэлхийн цаг уурын байгууллагын бүсийн сургалтын төв болох Солонгосын цаг уурын байгууллагад зохион байгуулагдах “Синоптик инженерүүдийн ур чадварыг дээшлүүлэх” сэдэвт олон улсын сургалтад хамрагдлаа.

Энэхүү олон улсын сургалтын зорилго нь цаг агаарыг урьдчилан мэдээлэхэд шаардлагатай хиймэл дагуулын /GK-2A/ болон радарын бүтээгдэхүүнүүд, цаг агаарын тоон загварын бүтээгдэхүүнүүд /WRF, KIM/, ажиглалтын мэдээнд дүн шинжилгээ хийх чадваруудыг нэмэгдүүлэх, далайн цаг уурын урьдчилсан мэдээ, мэдээний чанарыг сайжруулах, хиймэл оюун ухаан /AI/-д суурилсан загваруудын боловсруулах, үйл ажиллагааны төлөвлөгөө /Action plan/-г өдөр тутам ашиглах, мөн харилцагч байгууллагууд болон олон нийтэд цаг агаарын мэдээгээр үйлчлэх чадваруудыг дээшлүүлэхэд оршиж байсан.

Тус сургалтанд Лаос 2, Вьетнам 3, Филиппин 3, Индонез 3, Монгол 3 нийт 14 орны 14 хүн оролцсон ба Сөүл, Ханкук их сургуулийн багш нар, БНСУ-ын Цаг уурын газар, хиймэл дагуулын төв, далайн цаг уурын хэлтсийн инженер, багш нар хичээл заасан.



Сургалтын хугацаанд дараах агуулга бүхий бүлэг хичээлийг үзэж судаллаа.

- БНСУ-ын соёл, хэлний танилцуулга
- БНСУ-ын Цаг уурын ажиглалтын бодлого, сүлжээний танилцуулга
- Солонгосын цаг уурын байгууллагын тоон прогнозын загварууд ба дата ассимиляц;
- Цаг агаарын тоон прогнозын бүтээгдэхүүнүүдийн тухай
- Хиймэл дагуулын мэдээнд дүн шинжилгээ хийх;
- Бүс нутгийн болон орон нутгийн тоон загварын систем;
- Урьдчилан мэдээлэхийн тоон загварын баталгаажуулалт;
- Урьдчилан мэдээлэхэд зориулсан тоон загварын өгөгдлүүдийг ашиглах арга, технологи;
- Гамшгаас урьдчилан сэргийлэх цаг уурын мэдээллийн систем;
- Үр дүнд суурилсан урьдчилсан мэдээний танилцуулга.
- Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Хичээл бүрт онол болон практик хосолсон ба гэрийн даалгавар ч өгч байв.

Хичээлийн агуулгад тусгагдсаны дагуу Солонгосын үндэсний хиймэл дагуулын төвтэй танилцаж одоо ашиглагдаж буй Geo-Kompsat-2A хиймэл дагуулын үүсэл, хөгжлийн явц, түүний хэрэглээ, цаашдын хөгжлийн төлөвлөгөөний тухай танилцуулга бүхий жижиг музей үзсэн.



Сургалтад хамрагдаж буй улс орон бүр тухайн улс орны урьдчилан мэдээлэхийн онцлог болон улсын хэмжээний цаг уурын үйл ажиллагааны тухай танилцуулга тавьсан ба урьдчилсан мэдээлэх үйл ажиллагаанд хүндрэлтэй болон давуу талаа ярилцаж туршлага солилцсон. Мөн үйл ажиллагааны /эрчимжүүлэх/ төлөвлөгөөний тухай ойлголттой танилцаж улс орны онцлогоор шаардагдаж тулгамдаж буй асуудал дээр төлөвлөгөө боловсруулж түүнийгээ танилцуулан заавар, зөвлөмж авсан.

Солонгосын цаг уурын байгууллагаас ирж, очих нислэгийн зардал, хоолны зардал, зочид буудлын зардлыг хариуцсан.



#### Дүгнэлт:

Тус сургалт нь улс орнуудын онцлогтой өөрийн салбарыг харьцуулж сайн болон муу талаараа бид цаг уурын хөгжлөөрөө хаана байна вэ? цаашид бид ямархуу байдлаар ажиллавал зохимжтой вэ? гэх мэт олон зүйл бодогдуулсан өгөөжтэй сургалт байлаа. Улс орны цаг уурын салбар байгууллагууд өөр хоорондоо маш уялдаа холбоотой ажиллаж байна. Дата болон түүний боловсруулалт, багаж хэмжлийг шалгах, нарийвчал өндөр хүчин чадал бүхий олон тоног төхөөрөмжүүдийг хараад өөрийнхөө улсын БОХЗТЛ маань хэрхэн ажиллаж байгаа билээ гэх мэт бодол төрж

очиж үзэх сэдэл төрүүллээ. Мөн бид одоогийн нөөц бололцоогоо сайтар ашиглаж HIMAWARI-9 хиймэл дагууллын мэдээлэл дээр боловсруулалтыг хийж бага орон зайд гаргасан бүтээгдэхүүнийг нэмэх, WRF загвар дээр улс орны онцлогийг сайтар тусгаж боловсруулах, синоптик инженерүүд болон нийт бодлого тодорхойлж буй хүмүүст цаашид уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор гамшиг аюулыг өндөр таарцтай мэдээлэхэд нийт инженерүүдийг чадавхижуулах нь алсдаа маш чухал байгааг бодлогоор тодорхойлж урт хугацааны төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байгаа харагдлаа. Мөн гадаад хэлний тал дээр дор бүрнээ хэрэглээ талаас нь сайжруулах аль аль талдаа нэгнээ бодлогоор дэмжих нь олон үр дүнг цаашид авчирна гэж үзэж байна.



Тайлан бичсэн:

Урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер: *Ц.Баярмаа* Ц.Баярмаа